

**ЗГХЭГ-ЫН ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН**

2026.06.19

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний "Зорилго 4. Салбар болон орон нутгийн түвшинд бодлого зохицуулалтыг шинэ түвшинд хүргэнэ", холбогдох 11 зорилтын хүрээнд Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газраас 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 11 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	ХШУДАГ-аас өгсөн үнэлгээ
1.	Орон нутагт ипотекийн зээлийн мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод хүргэн хүртээмжийг сайжруулах	2	2	100%	90%
2.	"Khural.mn" сайтыг ил тод, ойлгомжтой, боловсронгуй болгож аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг тогтмол мэдээлэх	1	1	100%	80%
3.	Багийн Засаг дарга нарын чадавхыг бэхжүүлэх, анхан шатны нэгжээр дамжуулан төрийн ажилд орон нутгийн иргэд оролцох боломжийг сайжруулах	1	1	80%	70%
4.	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн захиргааны байгууллагад чиглэсэн хууль, тогтоомжийн төслийг боловсронгуй болгох	1	2	90%	90%
5.	Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллах, үүрэг даалгаврыг биелүүлэх	1	2	100%	100%
6.	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах	1	4	78%	76.25%
7.	Аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааг удирдлага,	1	14	99%	93.93%

	зохицуулалтаар хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
8.	Орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх болон хуулийн хэрэгжилтийн хүрээнд гарч байгаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх	1	5	96%	96%
9.	Баг, хорооны Засаг даргад Засгийн газрын бодлого, шийдвэрийг тухай бүр шуурхай хүргэх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх	1	1	100%	95%
10.	Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх	1	2	100%	86%
11.	Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Шадар сайдыг орон нутагт ажиллахад дагалдан явах, ёслол хүндэтгэлийн ажиллагааг зохион байгуулах	1	1	100%	100%
Дундаж ерөнхий үнэлгээ		11	35	94.5%	88,8%

Хүснэгт-2

ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ					
Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон.)
ОНУЗГ	11	35	23	12	-

ДҮГНЭЛТ

Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 94.5 хувиар үнэлж ирүүлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 88.8 хувиар үнэлэв. (ОНУЗГ-аас цаасаар ирүүлсэн тайланд гүйцэтгэлийн дундаж хувийг бодож ирүүлээгүй боловч арга хэмжээ бүрт өгсөн үнэлгээнээс гүйцэтгэлийн дундаж хувийг гаргахад 95 хувьтай байсан.) Гүйцэтгэлийн тайлангаас зарим арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хангагдаагүй, тайлагнал дутуу, шалгуур үзүүлэлтэд хүрээгүй буюу мэдээлэл дутуу байсан тул үнэлгээг бууруулж тооцсон.

Орон нутгийн удирдлага зохицуулалтын газар нь 2026 оны эхний хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хангалттай хэмжээнд хэрэгжүүлэн ажилласан байна.

Орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнд хүрсэн ажлаас дурдвал:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн захиргааны байгууллагын зохион байгуулалт, удирдлагыг боловсронгуй болгоход чиглэсэн хууль тогтоомж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг өгч хангалттай хэмжээнд ажилласан байна.
- Бүсийн зөвлөлийн анхдугаар хурал болон Засгийн газрын хурлын бэлтгэл ажлыг тус газар дээр нь урьдчилан очиж ажиллан зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, Монгол Улсын Ерөнхий сайдын орон нутагт ажиллах, бүсийн зөвлөлийн хуралд оролцох бэлтгэл ажлыг хангаж ажилласан байна.
- Орон нутаг, нийслэлийн удирдлагын байгууллагаас шийдвэрлүүлэх шаардлагатай асуудал, Ерөнхий сайдын орон нутагт томилолтоор ажиллахад авах арга хэмжээний талаар, нийслэлийн зарим тулгамдсан асуудлаар болон цаг үеийн шуурхай асуудлаар нийт 20 асуудлыг Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулж Засгийн газрын 1 тогтоол, 17 тэмдэглэл, 2 захирамжийг хууль тогтоомж, журамд нийцүүлэн албажуулсан.
- Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны тайлан мэдээг нэгтгэн боловсруулж Засгийн газрын хуралдаанд 2026 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр танилцуулан 13 дугаар тэмдэглэлийг гарган албажуулж, зөвлөмжийг аймаг, нийслэлд хүргүүлсэн.

Орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс анхаарах шаардлагатай ажлаас дурдвал:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн захиргааны байгууллагын зохион байгуулалт, удирдлагыг боловсронгуй болгоход чиглэсэн хууль тогтоомж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлийн бодлогын арга хэмжээг төлөвлөлтөд тодотгон эрчимжүүлэх шаардлагатай байна.
- Чанарын менежментийн олон улсын стандартыг нэвтрүүлээгүй нутгийн удирдлагын байгууллагуудад "MNS ISO-18091" стандартыг нэвтрүүлэхэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд зорилтот түвшинд хүрэхэд сүүлийн хагас жилийн ажлыг эрчимжүүлэх
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн холбогдох судалгааны ажил хийх, шинэ төлөөлөгчдийг сургах ажлыг ИТХ-ын Ажлын албадад зөвлөх, гүйцэтгэлийг сайжруулах, khural.mn вэбсайтын хэвийн ажиллагааг ханган сурталчлах зэрэг ажлыг эрчимжүүлэх.
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах хүрээнд тус хуулийн хэрэгжилтийг сунгасантай холбогдуулан хэрэгжих боломжгүй байсан нөхцөл байдлын гарц шийдлийг олох төлөвлөлтийг тодорхой болгож, орон нутагт зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажиллах
- Аймаг, нийслэлийн удирдлагуудын гадаад томилолтын удирдамжийг хянаж зөвшөөрөл олгох, гадаад харилцааны тайланг нэгтгэх ажлын хүрээнд гол шалгуур үзүүлэлтийг гадаад харилцааг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг сайжруулахад чиглүүлэх, энэ асуудлыг дэлгэрэнгүй тайлагнахад анхаарах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ


- Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь нутгийн удирдлагын байгууллагуудтай харилцахтай холбоотой ажил, үйлчилгээ үзүүлэхэд тулгуурласан тул үндсэн чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх ажлаас гадна Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэх, холбогдох асуудлыг боловсронгуй болгоход чиглэсэн шинэлэг ажлуудыг төлөвлөж байхад анхаарах
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилтын биелэлтийг хангахад чиглэсэн жижиг арга хэмжээнүүдийг нэгтгэн оновчтой тодорхойлж, тухайн арга хэмжээг дэвшүүлсэн зорилтын түвшинд уялдуулж, гарах үр дүн тоон болон чанарын үзүүлэлт ашиглан хэмжигдэхүйц байдлаар илэрхийлж, мөн арга хэмжээний биелэлтийг тодорхой өөрчлөлт, үр дүн гарсан эсэхийг хэмжигдэхүйц энгийн ойлгомжтой, цаг хугацаа, суурь түвшин, хүрсэн түвшинтэй харьцуулан өөрчлөлт гарсан эсэхийг нотолгоо баримттай тодорхой тайлагнах
- Гүйцэтгэлийн тайлан бичихдаа шалгуур үзүүлэлттэй нийцсэн тоон нотлох баримтыг оруулах, "зөвлөгөө, дэмжлэг өгсөн", "ажилласан" гэх ерөнхий тодорхойлолтоос зайлсхийж, тооцоолсон дүн, хэмжигдэхүйц өөрчлөлтийг тусгах.
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу сайжруулах, зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ
Б.ОРГИЛ

Хавсралт

Хүснэгт-3

ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН /ЗААЛТ БҮРЭЭР/				
Арга хэмжээний д/д	Арга хэмжээний дугаар	Өөрсдийн өгсөн үнэлгээ	ХШҮ хийсэн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Зорилт 1				
1	1.1	100	80	Ипотекийн зээлийн хэрэгжилт хагас жилд зорилтын 66%-д хүрсэн (3,582/5,400). Суурь түвшин (5,291) зорилтоос (5,400) ойрхон тул томъёо хэрэгжихгүй. Хагас жилийн биелэлтийг харгалзан бууруулсан
2	1.2	100	100	
Зорилтын үнэлгээ			90.00	
Зорилт 2				
3	2.1	100	80	Мэдээллийн тоо 4,977 хагас жилд; жилийн зорилтот 15,600-ын 32%-д хүрсэн. Суурь 15,586>зорилтот 15,600, шалгуур үзүүлэлтийн алдаа. Идэвхтэй ажилласан талыг харгалзан 80% үнэлэв
Зорилтын үнэлгээ			80.00	
Зорилт 3				
4	3.1	80	70	Сургалтын хөтөлбөр, төсвийг боловсруулсан боловч хагас жилд бодит сургалт хийгдээгүй. Зорилтот 1,570 БЗД-ын сургалт 2-р хагас жилд хэрэгжих нөхцлийг анхаарах
Зорилтын үнэлгээ			70.00	
Зорилт 4				
5	4.1	80	80	15 багц асуудал гаргаж ЗГ-ын хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон. Судалгааны ажил хийгдсэн
6	4.2	100	100	20 асуудлыг ЗГ-ын хуралдаанд танилцуулж 1 тогтоол, 17 тэмдэглэл, 2 захирамж гарсан
Зорилтын үнэлгээ			90.00	
Зорилт 5				
7	5.1	100	100	9 гаруй ажлын хэсэгт оролцож ажилласан нь нотлогдсон
8	5.2	100	100	Дэд ажлын хэсэг байгуулж бэлтгэл хийсэн; ЗГ-ын 120 дугаар тогтоолоор санал асуулга хойшилсон
Зорилтын үнэлгээ			100.00	
Зорилт 6				
9	6.1	100	95	3 хувилбар боловсруулж ЗГ-д танилцуулсан; хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан
10	6.2	70	70	Эхний хувилбар боловсруулсан; хуулийн шийдвэрийг хүлээж байна
11	6.3	70	70	хуулийн шийдвэрийн дараа ажиллахаар төлөвлөсөн

12	6.4	70	70	Ажлын хэсэг байгуулагдаагүй; шийдвэрийг хүлээж байна
Зорилтын үнэлгээ			76.25	
Зорилт 7				
13	7.1	100	100	18 аймаг, 16 суманд очиж ажилласан
14	7.2	100	95	Зөвлөгөө өгч ажилласан; ЗГ солигдсоны дараа тайлан авахаа зогссон
15	7.3	100	100	18 аймаг, 16 суманд ажилласан; Узбекистан, БНХАУ томилолт
16	7.4	100	100	1-р сарын 15-16-нд зохион байгуулсан; цахим уулзалт хийсэн
17	7.5	100	100	1-р сарын 15-нд аймаг, нийслэлийн ЗД нартай гэрээ байгуулсан
18	7.6	100	70	МТ, ЦХИХХЯ-тай хамтран ажиллаж байна; бодит үр дүн тайлагнагдаагүй
19	7.7	100	100	78 байгууллагад нэвтэрсэн; Завхан, Өмнөговь аймгуудад давтан баталгаажуулалт
20	7.8	80	80	Хангай, Хойд, Говийн бүсийн хурал зохион байгуулсан; Баруун болон бусад бүсүүд хойшилсон
21	7.9	70	70	4 бүсийн хурал болоогүй (Баруун, Зүүн, Төв, УБ); дүгнэлт зөвлөмж боловсруулсан
22	7.10	100	100	Зөвшөөрлүүдийг хянаж, санамж бичгийн төслүүдийг боловсруулсан
23	7.11	100	100	Аймгуудаас санал авч СХОГ-г хүргүүлсэн
24	7.12	100	100	6 бүсийн 18 аймагт ажилласан
25	7.13	100	100	4-р сарын 04-нд ЗГ-д танилцуулж 13 дугаар тэмдэглэл гарсан
26	7.14	100	100	293 суман ИТХ-ын дарга, 153 төлөөлөгч, баруун бүсийн 125 гишүүнд сургалт зохион байгуулсан
Зорилтын үнэлгээ			93.93	
Зорилт 8				
27	8.1	80	80	Судалгааг 21 аймгаас авсан; 7 аймгаас 10 орон тоо цомхотгох боломжтой гэсэн хариу авсан
28	8.2	100	100	Нийт 27 удаагийн цахим хурал зохион байгуулсан
29	8.3	100	100	Төвийн, Хойд, Говийн бүсэд мэдээлэл, бэлтгэл хийсэн
30	8.4	100	100	Танилцуулга, судалгаа, хэлэх үг бэлтгэж Ерөнхий сайдын ажлын алба, зөвлөхүүдэд хүргэсэн
31	8.5	100	100	Төвийн, Хойд, Говийн бүсийн аймгуудын уулзалтуудад бэлтгэл хийсэн
Зорилтын үнэлгээ			96.00	
Зорилт 9				
32	9.1	100	95	Фейсбүүк группээр мэдээлэл хүргэх тогтолцоо бүрдүүлсэн
Зорилтын үнэлгээ			95.00	

Зорилт 10				
33	10.1	100	100	447 албан бичиг, 71 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд шийдвэрлэсэн
34	10.2	100	72	ЗГХЭГ-ын даргын 47 шуурхай үүрэг даалгаврын биелэлт: 72.1%; ЗГ-ын 119, 127 тогтоолын биелэлт: 70%
Зорилтын үнэлгээ			86.00	
Зорилт 11				
35	11.1	100	100	26 удаагийн ёслолын ажиллагаа зохион байгуулсан (зорилтот 14-өөс давсан)
Зорилтын үнэлгээ			100.00	
Нийт дундаж үнэлгээ			88.8%	